

## УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ

- Гепатит В вирусийн эсрэг вакцин хамгийн сайн хамгаалалт болдог.



- Та бэлгийн олон хавьтагчтай, эсвэл нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орох болгондоо бэлгэвч хэрэглэх шаардлагатай.

- Та жирэмсэн бол гепатит В-ийн шинжилгээ хийлгэх хэрэгтэй. Гепатит В вирусийн халдвар авсан эхээс төрсөн хүүхдэд төрснөөс нь хойш 12 цагийн дотор гепатит В-ийн иммуноглобулин болон вакцин хийх шаардлагатай.



- Цус хүрсэн байж болох хувийн ариун цэврийн хэрэгслүүд (сахлын хутга, шүдний сойз г.м)-ийг бусадтай хувааж хэрэглэж болохгүй.

- Шивээс хийлгэх, чихээ цоолуулахын өмнө үүнтэй холбоотой эрсдлийн талаар сайтар бод! Шивээс хийдэг буюу чих цоолдог багаж дээр нь халдвар авсан хүний цус хүрсэн, түүнийг нь сайн ариутгаагүй тохиолдолд Танд халдвар дамжих аюултай гэдгийг санана уу?

- Та гепатит В-ийн халдвар авсан буюу өмнө нь авч байсан бол цус олон эд, эрхтний донор болохоос татгалзах хэрэгтэй.

- Та эмнэлэгт ажилладаг бол гепатит В-ийн эсрэг вакцин хийлгэж, хурц иртэй багаж хэрэгсэлтэй харьцахдаа аюулгүйн дүрэм журмыг чанд баримтлах шаардлагатай.

## ЭМЧИЛГЭЭ


В, С вирусийн эмчилгээ харилцан адилгүй, эмчилгээг эмчийн хатуу хяналт зааврын дор явуулах ёстой. Эмчилгээ эхлэхийн өмнө дараахийг анхаарна. Үүнд:

- Бүх төрлийн нарийн шинжилгээг хийлгэх, ялангуяа зүрх, уушиг, бамбай өвчний нарийн шинжилгээг эмчилгээ эхлэхийн өмнөхөн заавал хийх. Хэрэв шинжилгээгээр ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл нарийн мэргэжлийн эмчид үзүүлж эмчлүүлсний дараа эмчилгээнд орж болох эсэхийг шийдэх
- Элэгний С вирусийн дэд бүлэг төрлийг заавал тогтоох
- Элэг хэрхэн гэмтсэн эсэхийг цусны нарийн шинжилгээгээр мөн элэгний эхо, биопси зэрэг шинэ техник технологиор тодорхойлон байж элэгний эмчилгээнд оруулахыг зөвлөдөг.
- Гепатит В вирусийн халдвар авсан хүмүүст элэгний бусад өвчин байгаа эсэхийг тогтоох үзлэг, шинжилгээ хийнэ.
- Адефовир дипивоксил, альфа интерферон, зэрэг эмийг архаг гепатит В-тэй өвчтөнүүдийн эмчилгээнд хэрэглэхээр зөвшөөрсөн.
- Дээрх эмүүдийг жирэмсэн эмэгтэйчүүд хэрэглэж болохгүй.
- Архи хэрэглэх нь элэгний өвчинг даамжруулах эрсдэлтэй.

Францын  
**"ТАЛЫН МОНГОЛ"** нийгэмлэг  
[www.talynmongol.net](http://www.talynmongol.net)  
[presidence@talynmongol.net](mailto:presidence@talynmongol.net)



# ГЕПАТИТ В, С ВИРУСИЙН ТАРХАЛТЫГ ЗОГСООЁ!



УЛААНБААТАР  
2008

## В, С ВИРУСИЙН ТУХАЙ ТОВЧ

Одоогоор дэлхий дээр элгийг гэмтээгч 7 төрлийн вирус байдаг бөгөөд эдгээр нь дамжих зам, үзүүлэх хор уршгаараа харилцан адилгүй юм. Үүнээс В, С вирус нь манай оронд нэлээн өргөнөөр тархаж **элэгний архаг үрэвсэл улмаар хатуурал, хорт хавдрыг үүсгэж үхэлд хүргэж байгаа** гол шалтгаануудын нэг болж байна.

### Вируст гепатитын шалтгаан

- Вируст гепатит буюу шар өвчин нь 7 төрлийн (A, B, C, D, E, F, G) вирусээр үүсгэгддэг ба эдгээрээс гепатит В вирусийн халдвар хүмүүсийн дунд нэлээд тархсан, хор уршиг ихтэй байдаг.
- Гепатит В вирусийн халдварлах чадвар нь ДОХ үүсгэдэг хүний дархлал хомсдлын вирусийн халдварлах чадвараас 100 дахин их юм.
- Гепатит В вирус нь халдвар авсан хүний цус, биеийн бусад шингэн (үрийн шингэн г.м)-д байдаг.
- Гепатит В вирусийн халдвар авсан хүн мөн гепатит Д вирусийн халдвар авч болдог ба ингэсэн тохиолдолд өвчин нэлээд хүндэрдэг байна.
- Халдварын нууц хугацаа (өөрөөр хэлбэл, халдвар авснаас хойш өвчний шинж тэмдэг илэртэл үргэлжлэх хугацаа) нь дунджаар 16 долоо хоног буюу 4 сар байдаг.

## Халдвар авах эрсдэлтэй хүмүүс

- Бэлгийн олон хавьтагчтай хүмүүс буюу бэлгийн замаар дамжих халдвартай хүмүүс
- Гомосекс эрчүүд
- Халдвар авсан хүний бэлгийн хавьтагчид
- Мансууруулах бодис тарьж хэрэглэдэг хүмүүс
- Ужиг халдвартай хүнтэй хамт амьдардаг хүмүүс
- Халдвар авсан эхээс төрсөн хүүхдүүд
- Эмнэлгийн ажиллагсад
- Гемодиализ эмчилгээ хийлгэдэг хүмүүс

### Дараах тохиолдлуудад гепатит В вирусийн халдвар авах эрсдэлтэй

- Халдвар авсан хүнтэй бэлгэвчгүйгээр бэлгийн хавьталд орох
- Халдвартай хүний хэрэглэсэн зүү, тариураар тариулах буюу хатгуулах
- Халдвар авсан хүний цус хүрсэн багажаар шивээс хийлгэх буюу чих цоолуулах
- Шүдний сойз, сахлын хутга зэрэг хувийн ариун цэврийн хэрэгслийг халдвар авсан хүнтэй хувааж хэрэглэх
- Халдвар авсан хүнд хазуулах
- Төрөх үед халдвар авсан ээжээс хүүхдэд дамжих

## Вируст гепатитээр өвдсөн хүнд дараах шинж тэмдгүүд илэрч болно.

- Амархан ядрах
- Хоолонд дургүй болох
- Халуурах
- Суулгах
- Шээс өтгөрөх
- Өтгөний өнгө цайвар болох
- Арьс, нүд зэрэг шар туяатай болох

Гэхдээ халдвар авсан ч ямар нэгэн шинж тэмдэг, зовиур илрэхгүй байж болдгийг анхаарна уу.

### Архинаас үүдэлтэй элэгний гэмтэл

